



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 10 сарын 12 өдөр

Дугаар A/71


Улаанбаатар хот

Г Байгалийн ургамлыг түүж бэлтгэх,
зөвшөөрөл олгох, тушаал хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.1, Байгалийн ургамлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, 17 дугаар зүйлийн 17.1, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн 4.1.4, Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 73 дугаар хуралдааны тэмдэглэл, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 2 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгалийн нөхөн сэргээгддэг нөөцийг зохистой ашиглах үүднээс Дэрэвгэр жиргээрүү /Saposhnikovia divaricata/-г түүж бэлтгэх зөвшөөрлийг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдэд 360 тоннд багтаан 2016 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн олгосугай.
2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын Сайдын 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн A/377 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Дэрэвгэр жиргээрүүгийн тархац, биологийн нөөц тогтоох ажлыг 2017 оны III улиралд багтаан, түүж бэлтгэх стандарт боловсруулахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Д.Даваасамба/-т даалгасугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Д.Даваасамба/-т даалгаж үүрэг болгосугай.

САЙД



Д.ОЮУНХОРОЛ

Оюунхорол